



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 10 сарын 08 өдөр

Дугаар А/554

Есөнбулаг сум


Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17.1.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.4, 2.1.6 дахь заалт, 4.1 дэх хэсэг, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 37 дугаар тогтоол, Засаг даргын удирдлагын зөвлөлийн 2025 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн 26 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүүхдийн эрх, хамгааллын талаарх олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх, хүүхдийн дуу хоолойг сонсох, бүтээлч сэтгэлгээг дэмжих зорилгоор зохион байгуулсан "Хүүхдийн гар зураг, эссэ бичлэгийн уралдаан"-нд шалгарсан хүүхдүүдийн шагналын зардалд шаардагдах 3,450,000 (гурван сая дөрвөн зуун тавин мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

2. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ), Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Д.Буянхишиг), Нийгмийн бодлогын хэлтэс (Ж.Амгаланбаатар) -т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

